




**ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН
ПРОФЕССОР, БАГШ НАРЫН АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭЛИЙГ БАГЦ ЦАГААР ТООЦОЖ, ҮНЭЛЭХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь ҮБХИС–ийн профессор, багш нарын гүйцэтгэсэн сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг тодорхойлон багц цагаар үнэлж, цалин хөлс, урамшуулал олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Үндэсний батлан хамгаалахын их сургууль нь сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, үйлчилгээндээ Боловсролын тухай багц хуулиуд, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам болон энэхүү журмыг баримтална.

1.3. Профессор, багшийн хөдөлмөр нь их сургуулийн үндсэн үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. Үүнд:

- а) Сургалт (А цаг);
- б) Эрдэм шинжилгээ, судалгаа, инновац (Б цаг);
- в) Сургууль, олон нийтийн бусад ажил, үйлчилгээ (В цаг),
- г) Багшийн хөгжил (Г), (цаашид А, Б, В, Г цаг гэх);

1.4. Профессор, багшийн сургалтын ажлын гүйцэтгэл нь мэргэжлийн болон техникийн, бакалаврын, магистрын, докторын, боловсролын зэргийн бус сургалтуудаас бүрдэнэ.

1.5. Профессор, багшийн А, Б, В, Г-цагийн үнэлгээ ижил байна.

1.6. Профессор, багшийн нэг багц цаг нь сургалтын ажлын 48 цагтай тэнцүү байна.

Сургалтын үйл ажиллагаа нь сургалтад бэлтгэх, танхимын сургалт, зөвлөгөө өгөх, суралцагчдын мэдлэг чадварыг үнэлэх гэсэн хэсгүүдээс дараах багцыг нэг багц цаг гэж тооцно.

Хүснэгт 1

Хөтөлбөрийн түвшин	Хичээлийн хэлбэр		
	Лекц	Семинар/Практик	Лаборатори/Дадлага
	Багц цаг (Хуваарьт цаг + Суралцагчийн бие даан суралцах цаг)		
Дэд бакалавр, Бакалавр	16+32	32+16	48+0 эсвэл 32+16
Ахисан түвшин	12+36	24+24	

Нийгэм, хүмүүнлэгийн ухааны хичээлийг 32+16, цэргийн мэргэжлийн болон байгаль, техникийн ухааны хичээлийг 48+0 хэлбэрээр тооцно.

1.7. Энэхүү журам нь багш, гэрээт, цагийн багш нарт нэг адил хамаарна.

ХОЁР. ПРОФЕССОР, БАГШ НАРЫН АЖЛЫН НООГДОЛ

2.1. Нэг хичээлийн жилд профессор, багшийн ажлын гүйцэтгэлийн ноогдол тэдний албан тушаалын шатлалаас үл хамаарч нийт 25 багц цаг /А нормт+ Б нормт+ В нормт+Г нормт/ байна.

2.2. Профессор, багш нарын А, Б, В, Г цагийн ноогдлын харьцаа нь дараах хувь хэмжээтэй байна.

Профессор, багшийн А, Б, В, Г багц цагийн ноогдол харьцаа

Хүснэгт 3

№	Албан тушаалын шатлал	Сургалтын цаг /А/	Эрдэм шинжилгээ, судалгаа, инноваци /Б/	Сургууль олон нийтийн ажил, үйлчилгээ /В/	Багшийн хөгжил /Г/	Нийт ноогдол багц цаг
1	2	3	4	5	6	7
1	Тэнхимийн дарга	8	10	5	2	25
2	Эрдмийн зэрэгтэй профессор	13	9	2	1	25
3	Эрдмийн зэрэгтэй дэд профессор	14	8	2	1	25
4	Албан тушаалын профессор	15	7	2	1	25
5	Албан тушаалын дэд профессор	16	6	2	1	25
6	Ахлах багш	17	5	1.5	1.5	25
7	Багш, тестийн мэргэжилтэн	18	4	1.5	1.5	25
8	Багш	18	4	1.5	1.5	25
9	Дадлагын багш	12	2	1.5	1.5	17

1. БШУ-ны сайдын 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн тушаалын 20.7 дугаар заалт + Багц цагийн хэмжээ нь дэд бакалаврын зэрэгт 90 багц цагаас доошгүй, бакалаврын зэрэгт 120 багц цагаас доошгүй, магистрын зэрэгт 30 багц цагаас доошгүй, докторын зэрэгт 60 багц цагаас доошгүй байна.

2. МУ-ын 2018 оны 6-р сарын 27-ны өдрийн "Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль"-ийн 3.1.2 заалт - "багшийн хөгжил" гэж багшийн мэдлэг, арга зүй, ур чадвар, боловсролоо дээшлүүлэх тасралтгүй үйл явцыг;

3. МУ-ын 2023 оны 07 сарын 07 өдрийн "Боловсролын ерөнхий хууль"-ийн 13.2.10 заалт - ажлын байранд болон бусад хэлбэрээр мэргэжлээ дээшлүүлэн, өөрийгөө хөгжүүлж, бусадтай хамтран ажиллах, бусдыг хүндэтгэх;

Тайлбар:

Багц цагт шилжүүлэх үндэслэл нь:

Профессор, багшийн хичээлийн жилийн туршид гүйцэтгэвэл зохих 25 багц цагийн ноогдлыг 48 цагаар /1багц=48/ үржүүлж, тухайн хичээлийн жилд ноогдох нийт ажлын цагийг тооцвол 1200 цагтай тэнцүү байна.

Нэг хичээлийн жил нь сургалтын 32 долоо хоногоос бүрдэх бөгөөд багш нэг долоо хоногт 37.5 цагийн ачаалал гүйцэтгэх буюу өдөрт 7.5 цагийн хөдөлмөр эрхэлнэ. /1200:32=37.5 цаг/

2.3. Профессор, багш нар нь өөрийн ажиллаж байгаа албан тушаалд харгалзах багц цагийн ноогдлыг /А, Б, В, Г/ заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд дутуу гүйцэтгэсэн тохиолдолд нэг багцын үнэлгээгээр тооцож мөнгөн суутгал хийнэ.

2.4. Профессор, багш ноогдолт А, Б цагийн гүйцэтгэлийг биелүүлээгүй тохиолдолд шилжүүлэн тооцож болно. Нөхөж тооцохдоо шилжүүлэх багцыг 0.8 коэффициентээр үржүүлнэ. В, Г цагийн гүйцэтгэлийг заавал биелүүлнэ.

2.5. Ноогдлоос давуулан биелүүлсэн гүйцэтгэлийг зөвшөөрөгдөх илүү багц цагаар тооцно. Зөвшөөрөгдөх илүү багц цаг нь тухайн профессор багшийн албан тушаалд харгалзах А+Б багц цагийн ноогдлын 50%-иас хэтрэхгүй байна.

2.6. Хүндэтгэх шалтгаантай профессор, багшийн А цагийн ноогдлыг орлон заасан цагийн гүйцэтгэл нь тухайн багшийн А цагийн ноогдлоос хэтрэхгүй байна. Ноогдлоос давуулан биелүүлсэн сургалтын илүү багц цагийн хөлсийг бодит гүйцэтгэлээр тооцож олгоно.

2.7. Профессор, багш нь А, Б цагийн гүйцэтгэлийг сар бүр тооцож, А, Б, В, Г цагийн гүйцэтгэлийг хичээлийн жилийн эцэст нэгтгэж гаргана.

2.8. Профессор, багшийн гүйцэтгэсэн багцын тооцоог гаргаж, мэргэжлийн тэнхимийн дарга, тухайн сургуулийн ЭШСА-аар хянуулан, бүрэлдэхүүн сургуулийн захирлаар батлуулан, Сургалтын болон Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтэс нягтлан шалгаснаар Сургалт хариуцсан дэд захирлын зөвшөөрлийг үндэслэн ҮБХИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.

2.9. ҮБХИС-д болон бүрэлдэхүүн сургууль, мэргэжлийн тэнхимд гэрээгээр ажиллаж буй тэргүүлэх, зөвлөх профессорууд А+Б сургалтын ажлын багц цагийн 50 хувиас доошгүй ноогдлыг гүйцэтгэнэ. /Бусад тохиолдолд гэрээ байгуулна./

Хүснэгт 4

Албан тушаал	Сургалтын заавал биелүүлэх ноогдол	Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн ажлын багц	Сургууль олон нийтийн ажил, үйлчилгээ
1	2	3	4
Тэргүүлэх профессор	6	-	-
Зөвлөх профессор	6	-	-
Профессор	7	-	-

ГУРАВ. ПРОФЕССОР, БАГШ НАРЫН БАГЦ ЦАГИЙН ТООЦОО

3.1. Профессор, багш нарын гүйцэтгэсэн А багц цагийг дараах байдлаар тооцно.

3.1.1. Багшийн сургалтын ажлын гүйцэтгэсэн багц цагийг багш нарын заасан гүйцэтгэлээр тооцно. Үүнд:

А. Лекцийн хичээлийн бүлгийн тоог харгалзсан бодит цагийн гүйцэтгэл (багшийн удирдлага буюу танхимын сургалт)-ийн 16 цаг нь 1 багц цаг байна.

В. Семинарын хичээлийн бүлгийн тоог харгалзсан бодит цагийн гүйцэтгэл (багшийн удирдлага буюу танхимын сургалт)-ийн 32 цаг нь 1 багц цаг байна.

С. Лаборатори ба дадлагын хичээлийн бүлгийн тоог харгалзсан бодит цагийн гүйцэтгэл (багшийн удирдлага буюу танхимын сургалт)-ийн 48 цаг нь 1 багц цаг байна.

Д. Тухайн хичээлийг сонгосон лекцийн ангид хичээллэсэн оюутны тоо 70-аас их байвал 70-аас давсан оюутан бүрт багшаас оюутны бие даалтыг шалгах шалгалт, сорил, тест авахад нь зориулж лекцийн 1 багц цаг тутамд оюутан бүрт 0.01 багц цагийг багшид тооцно.

Тухайн хичээлийн жилд профессор багшид ноогдох нийт багц цагийг дараах илэрхийллээр бодно.

$$Ch = t = 1nCh_{lects.t} + Ch_{sem.i} + Ch_{lab.dad.tdt} + Chi > 70$$

Энд:

n - энд тухайн улиралд багшийн заасан хичээлийн тоо

l - Хичээлийн дугаар

$Ch_{lects.i}$ - i - Хичээлийн лекцээс багшид тооцогдсон багц

$Ch_{sem.i}$ - i - Хичээлийн семинараас багшид тооцогдсон багц

$Ch_{lab.dad.i}$ - i - p хичээлийн лаборатори ба дадлагаас багшид тооцогдсон багц

$Ch_{\text{тест}}$ – I-р Тухайн хичээлийн 70-аас дээш давсан оюутны бие даалтыг шалгах, сорил авах, тест, шалгалт авахад багшаас оюутантай ажилласан цагт ноогдох багц

d. i-р Хичээлийн агуулгын түвшинд харгалзах итгэлцүүр

Дээд боловсролын суурь болон

Мэргэжлийн суурь хичээлүүд $d_i=1.0$

Мэргэжлийн хичээлүүдэд $d_i=1.2$

3.1.2. Бодит гүйцэтгэлийн багц Ch -г хичээлийн чанарын үзүүлэлтийн коэффициентээр (K) үржүүлэн гарсан багц цагийг багшид олгоно.

$$Ch_{\text{тех}} = Ch \cdot Kch$$

K –хичээлийн чанарын үзүүлэлтийн коэффициент $0.9 \leq Kch \leq 1.1$ байна. Сургалтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор бүрэлдэхүүн сургууль тус бүр өөрийн онцлогийг харгалзан чанарын үзүүлэлтийг илэрхийлэх шалгуур үзүүлэлтийг тогтоож сургуулийн захиргааны зөвлөлөөр хэлэлцүүлэн тушаалаар баталгаажуулна.

3.1.2.1. Бакалаврын түвшний сургалтад 30 хүртэлх сонсогчийг хичээлийн үндсэн анги болгон тооцож, сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан тухайн хичээлийн багц цагийг багшид бүрэн олгох зарчим баримтална. Үндсэн бүлгийн энэхүү багц цаг нь багшийн багц хөдөлмөрийг илэрхийлнэ. Үүнд: Тухайн хичээлийн лекц, лаборатори, семинар, дадлагын хичээл, бие даалт, иж бүрэн тест, явцын сорил, улирлын шалгалт, тусдаа сургалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй курсийн төсөл, ажил болон хичээлийн e-файл бүрдүүлэлт зэрэг байна.

3.1.2.2. Семинар, лаборатори, дадлагын хичээлийн бүлгийг 30 хүртэлх суралцагчтайгаар зохион байгуулна.

3.1.2.3. ҮБХИС-ийн нэрийн өмнөөс олимп, дэлхий, тив, олон улс, улс, салбарын болон оюутны улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд баг, тамирчид бэлтгэн оролцуулсан болон өөрийн биеэр оролцон шагналт байрт шалгарсан тохиолдолд удирдсан багш-дасгалжуулагчдад дараах гүйцэтгэлүүдийг сургалтын багц цагт нэмж тооцно.

Хүснэгт 5

№	Их сургуулийн нэрийн өмнөөс өөрийн биеэр эсхүл баг, тамирчин дасгалжуулж	Амжилт	Багц цаг
1	2	3	4
1	Олимп, дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээнд	Медаль хүртсэн	3.0
2	Олон улсын бусад тэмцээнд	Медаль хүртсэн	2.0
3	Улс, салбар, оюутны аварга шалгаруулах тэмцээнд	Медаль хүртсэн	1.0

3.1.3. Бакалаврын дипломын төсөл, ажил удирдсан багшид ажил тус бүрт 1 багц цаг "Б" цаг тооцно.

3.1.4. Сонсогч, оюутны танилцах, мэргэжлийн, цэргийн хэргийн болон үйлдвэрлэлийн дадлага удирдахад нэг бүлэгт багшид ноогдох багцыг ажлын 5 хоногт 1 багц цаг байхаар тооцно. Нэг бүлгийн дадлагыг хоёр болон түүнээс дээш профессор, багш удирдсан тохиолдолд багц цагийг хуваан олгоно.

$$Ch_d = 0.06 C_d$$

3.1.5. Профессор, багш 2 хүртэл бакалаврын дипломын ажил, эрдмийн зэрэг, цолтой багш нар 3 хүртэл магистрын судалгааны ажил, 3 хүртэл докторын диссертаци удирдаж болно. Тухайн багш 3 хүртэл докторын ажилд зөвлөх комиссын гишүүнээр ажиллаж болох ба нийт удирдах, зөвлөх комиссын гишүүнээр ажиллах докторантын тоо 3-аас илүүгүй байна.

3.1.6. Бакалаврын дипломын ажлын шүүмж тус бүрт 0.1 багц цагийг "Б" цагт тооцно.

3.1.7. Докторын диссертаци, магистрын судалгааны ажил удирдах, хамгаалуулахтай холбоотой багц цагийг удирдагч, шүүмжлэгч, зөвлөлийн гишүүдийн эрдмийн зэрэг, цолд харгалзан дараах байдлаар тооцож, суралцагч өөрөө хариуцна. Багц цагийг "Б" цагт давхардуулж тооцохгүй. Үүнд:

- Докторын диссертаци удирдахад /ажил бүрт/ 3 багц цаг
- Магистрын судалгааны ажил удирдахад /ажил бүрт/ 2 багц цаг
- Докторын диссертацид албан ёсны шүүмж бичихэд /шүүмж бүрт/ 1.0 багц цаг
- Магистрын судалгааны ажилд албан ёсны шүүмж бичихэд /шүүмж бүрт/ 0.5 багц цаг
- Зөвлөх комиссын гишүүнээр ажилласан багшид 1,0 багц цаг

- Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дарга, гишүүдэд 0.5 багц цаг
- Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дарга, гишүүдэд 0.4 багц цаг
- Мэргэжлийн магистрын дадлагын тайлан хамгаалалт 0.2 багц цаг
- Тэнхимийн өргөтгөсөн хэлэлцүүлэгт оролцсон багш нарт 0.1 багц цагийг сургалтын ажлын хэсэгт тооцно.

3.1.8. Доктор, магистр, бакалаврын түвшний сургалтад зайн хэлбэрээр суралцаж буй, нэг хичээлээр 30 хүртэлх суралцагчдад хичээл заасан багш нарын багц цагийг тооцохдоо өдрийн сургалтын аргачлалуудаар бодож, гарсан дүнг зайн сургалтын итгэлцүүр $K_{3/c}$ -ээр үржүүлэн багшид ноогдох багц цагийг тооцно. Зайн сургалтын энэхүү итгэлцүүр нь бакалаврын түвшний сургалтад $K_{3/c}=1.2$; магистр, докторын түвшний сургалтад $K_{3/c}=1.3$ байна.

3.1.9. Өвөл, зуны давтан сургалтад хичээл заасан багш нарын багц цагийн тооцоог доорх томъёогоор бодож үнэлгээг энэ журмын 2.6-д зааснаар, сургалтын заавал биелүүлэх багц цагаас тусад нь тооцно. Өвөл, зуны сургалт ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээлүүдээр зохион байгуулагдана.

$$Ch = t = 1_n Ch_{tects.t} + Ch_{sem.i} + Ch_{tab.dad.tdi}$$

Энд:

- n Багшийн өвөл зуны сургалтад заасан хичээлийн тоо
- i Хичээлийн дугаар
- $Ch_{tects.t}$ $Ch_{tects.t}$ Тухайн хичээлийн лекцээс багшид тооцогдсон багц
- $Ch_{sem.i}$ $Ch_{sem.i}$ Тухайн хичээлийн семинараас багшид тооцогдсон багц
- $Ch_{tab.dad.t}$ $Ch_{tab.dad.t}$ Тухайн хичээлийн лаборатори болон дадлагаас багшид тооцогдсон багц
- d_i d_i Хичээлийн агуулгын түвшинд харгалзах итгэлцүүр

$d_i = 1.0$ $d_i = 1.0$ Дээд боловсролын суурь болон мэргэжлийн суурь хичээлүүдэд

3.1.10. Дэд бакалавр, бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрт тусгагдсан гадаад хэлнээс бусад хичээлүүдийг сургалтын ажлын зайлшгүй шаардлагаар гадаадын аль нэг хэл дээр бүрэн заасан тохиолдолд дээрх аргачлалуудаар бодож, багшид ноогдох багц цагийг 50 хүртэл хувиар нэмэгдүүлэн тооцно.

3.1.11. Эчнээ сургалтад хичээл заасан багш нарын багц цагийн тооцоог энэ журмын 3.1.1-д зааснаар тооцно.

3.1.12. Мэргэжлийн багш хүрэлцэхгүй тохиолдолд магистраас доошгүй зэрэгтэй, тухайн мэргэжлийн хүнийг гэрээт багшаар ажиллуулж болно. Гэрээт багшийн сургалтын ажлын багц цагийг үндсэн багшийн ажлын гүйцэтгэл тооцох аргачлалын дагуу бодно.

3.1.13. Суралцагчийн чиглүүлэгч (бүлэг, секц, дугуйлан, клуб)-ээр ажилласан багшид улиралд 2 багц цагийг сургалтын багцад илүү цагаар нэмж тооцон улирал тутам олгоно.

3.2. Профессор багш нарын Б цагийн гүйцэтгэлийг дараах байдлаар тооцно.

3.2.1. Эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл, бүтээл бичин хэвлүүлэх

Хүснэгт 7

№	А. Эрдэм шинжилгээний өгүүлэл	Хэмжих нэгж	Багц цаг
1	2	3	4
Гадаадад ЭШ-ий өгүүлэл хэвлүүлэх			
1	Олон улсын шинжлэх ухааны мэдээллийн санд бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүл (Web of science, Scopus)-д нэгдүгээр зохиогч, эсвэл холбоо баригчаар өгүүлэл хэвлүүлэх ¹	1 өгүүлэл	7.0
2	Тухайн мэргэжлийн чиглэлээр хянан магадалгаа хийгддэг олон улсын мэдээллийн санд бүртгэлтэй Q1, Q2, Q3, Q4-р зэргийн мэргэжлийн сэтгүүл (Web of science (Impact Factor (IF)), Scopus (SJR (SCImago Journal Rank)), Google Scholar (GSJ (Google Scholar Journal)), Wiley)-д өгүүлэл хэвлүүлэх ²	1 өгүүлэл	4.0

¹ 1-р зохиогчид 3.0 багцыг, холбоо баригч болон бусад зохиогчдод 4.0 багцыг тэнцүү хувааж олгоно.

² 1-р зохиогчид 2 багцыг, холбоо баригч болон бусад зохиогчдод 2.0 багцыг тэнцүү хувааж олгоно.

3	Хянан магадалгаа хийгддэг дотоодын /DOI дугаартай/ болон олон улсын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх ³	1 өгүүлэл	3.0
4	Мэргэжлийн түвшинд хянагддаггүй гадаадын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх (DOI, Semantic Scholar, Dimensions a Digital Science Solution)	1 өгүүлэл	2.0
5	ҮБХИС-иас эрхлэн гаргадаг "Цац" хянан магадалгаа хийгддэг олон улсын сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх ⁴	1 өгүүлэл	1.0
6	Гадаадад зохион байгуулсан олон улсын хурлын эмхэтгэлд бүрэн хэмжээний өгүүлэл хэвлүүлэх	1 өгүүлэл	1.5
7	Олон улсад хэвлэгдсэн бүтээлд шүүмж бичих	1 өгүүлэл	1.0
8	Гадаадад зохион байгуулсан олон улсын хурлын эмхэтгэлд хураангуй хэвлүүлэх	1 илтгэл	0.5
Дотоодод ЭШ-ний өгүүлэл хэвлүүлэх			
9	Дотоодод зохион байгуулсан олон улсын хурлын эмхэтгэлд бүрэн хэмжээний өгүүлэл хэвлүүлэх /гадаад хэлээр/	1 өгүүлэл	1.2
10	Их сургуулиудын эрдэм шинжилгээний бичигт өгүүлэл хэвлүүлэх	1 өгүүлэл	1.0
11	Мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	1 өгүүлэл	
12	Дотоодод зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд бүрэн хэмжээний өгүүлэл хэвлүүлэх	1 өгүүлэл	
13	Сургуулийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн, томилгоот ажил үйлчилгээ /сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан, урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг/	1 ажил	0.5
14	Аман ба бичгийн орчуулга	1 цаг	0.1
		400 үг	0.3
15	Дотоодод зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд өгүүллийн хураангуй хэвлүүлэх	1 илтгэл	0.3
Б. Эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлэх			
1	Монограф /нэг сэдэвт зохиол/	1 х.х	0.3
2	Гадаад хэлээр бичигдсэн монограф	1х.х	0.8
3	Шинжлэх ухааны доктор /Sc.D/-ын диссертаци	1ажил	7.0
4	Доктор /Ph.D/-ын диссертаци	1 ажил	5.0
5	Сурах бичиг	1 х.х	0.4
6	Орчуулгын бүтээл	1х.х	0.3
7	Гарын авлага	1 х.х	0.2
8	Цахим ном /материал/ сурах бичиг, гарын авлага	1 х.х	0.2
9	Эрдэм шинжилгээний тайлан	1 ажил	0.5
10	Кейс боловсруулах /Бүрэн хэмжээний бүтээлийн боловсруулалтаар/	1 ажил	0.1
11	Эшлэл татагдсан бүтээл /олон улсад/	1 ишлэл	0.2
12	Эшлэл татагдсан бүтээл /дотоодод/	1 ишлэл	0.1
1	2	3	4
13	Цэргийн үлээвэр найрал хөгжимд зориулсан бүрэн хэмжээний бүтээл туурвих - Цэргийн үлээвэр хөгжимд зориулсан марш - Симфони хэлбэрийн зохиол	1	2.0

Тайлбар:

- Судалгааны тодорхой чиглэлээр өөрийн хэвлэн нийтлүүлсэн эрдэм шинжилгээний үр дүнг үндэс болгон бусад эрдэзнэхийн судалгааны үр дүнтэй харьцуулан нэгтгэж, асуудлыг тал бүрээс нь авч үзэж, шийдэгдсэн болон шийдэгдээгүй асуудлууд, тэдгээрийн онол, практикийн ач холбогдлыг харуулсан бүтээлийг нэг сэдэвт бүтээл буюу монограф гэж үзнэ. Бүтээлийг ҮБХИС-ийн эрдмийн зөвлөл, хэвлэл редакцын зөвлөлөөр тус тус хэлэлцэж зөвшөөрсөн байна.

³ 1-р зохиогчид 1 багц цаг, 2 ба бусад зохиогчдод 2.0 багц цагийг тэнцүү хувааж олгоно.

⁴ Багш нарт багц цагаар, мэргэжилтэн судлаачдад олон улсын сэтгүүлд өгүүлэл бичсэн зардлыг олгох журмаар давхацуулахгүйгээр олгоно.

- Гадаад хэл дээрх монографыг олон улсын хэвлэлийн индексээр (SPI) тодорхойлох ба тодорхойлох боломжгүй (эсвэл монгол хэл дээр бичигдсэн) тохиолдолд хэвлэлийн газар, редакцын түвшин, хэвлэгдсэн тоо зэрэгт үндэслэн мэргэжлийн эрдэмтэд шинжээчдийн дүгнэлтээр бүрэлдэхүүн сургуулийн "Сургалт арга зүйн зөвлөл" тодорхойлно. Үнэлгээг ҮБХИС-ийн эрдэм шинжилгээ хариуцсан нэгж зохион байгуулна. Олон зохиогчтой тохиолдолд зохиогчийн оролцоо тодорхой бол харгалзах хэвлэлийн хуудсаар нь, тодорхойгүй бол тухайн тохиолдолд багц цагийг бүх оролцогчдод тэнцүү хувааж тооцно. Сурах бичгийг дахин хэвлүүлсэн тохиолдолд зөвхөн нэмэгдсэн агуулгад харгалзах хэвлэлийн хуудаст ноогдох багц цагийг тооцно.
 - Олон улсын мэргэжлийн сэтгүүлд бүтээл хэвлүүлсэн багш, судлаачдад судалгааны ажлын зардал олгох журмын дагуу зохих зардлыг олгосон бол гадаадад эрдэм шинжилгээний өгүүлэл бичсэнийг энд давхардуулан олгохгүй.
ЛБХИС-ийн захирлын 2024 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Олон улсын мэргэжлийн сэтгүүлд бүтээл, хэвлүүлсэн багш судлаачдад судалгааны ажлын зардал олгох" журамтай давхцуулан олгохгүй/
 - Сурах бичиг, орчуулгын бүтээл, гарын авлага нь сургуулийн эрдмийн болон хэвлэл редакцын зөвлөлөөр зөвшөөрөгдсөн байх ба олон зохиогчтой тохиолдолд зохиогчдын оролцоо тодорхой бол харгалзах хэвлэлийн хуудсаар нь, зохиогчдын оролцоо тодорхойгүй бол багц цагийг бүх оролцогчдод тэнцүү хувааж тооцно. Сурах бичгийг дахин хэвлүүлсэн тохиолдолд зөвхөн нэмэгдсэн агуулгад харгалзах хэвлэлийн хуудаст ноогдох багц цагийг тооцно.
 - Цахим ном тооцуулах тохиолдолд их сургуулийн ном, сурах бичигт тавигдах шаардлагыг хангасан байна.
 - Ном, сурах бичиг, гарын авлагыг хэвлэлийн хуудсыг тооцохдоо "ҮБХИС-иас сонин, сэтгүүл гаргах, ном, сурах бичиг, гарын авлага хэвлүүлэхэд баримтлах журам"-ыг үндэслэнэ.
 - Ном, сурах бичиг, гарын авлагыг редакцын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тооцно.
 - Нэг бүтээлийн эхийг цахим болон хэвлэмэл байдлаар давхардуулж тооцохгүй.
- ¹ 1-р зохиогчид 3.0 багц цаг, холбоо баригч болон бусад зохиогчдод 4.0 багц цагийг тэнцүү хувааж олгоно.
- ¹ 1-р зохиогчид 2 багц цаг, холбоо баригч болон бусад зохиогчдод 2.0 багц цагийг тэнцүү хувааж олгоно.
- ¹ 1-р зохиогчид 1 багц цаг, 2 ба бусад зохиогчдод 2.0 багц цагийг тэнцүү хувааж олгоно.
- ¹ Багш нарт багц цагаар, мэргэжилтэн судлаачдад олон улсын сэтгүүлд өгүүлэл бичсэн зардлыг олгох журмаар давхцуулахгүйгээр олгоно.

3.2.2 Эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэх

Хүснэгт 8

№	Илтгэл	Хэмжих нэгж	Багц цаг
1	2	3	4
I	Гадаад зохион байгуулсан олон улсын хурал		
1	• Уригдсан илтгэл /keynote, resource person/	1 илтгэл	3.0
2	• Илтгэл	1 илтгэл	2.0
II	Дотоодод зохион байгуулсан олон улсын хурал ⁴		
1	• Уригдсан илтгэл /keynote, resource person/	1 илтгэл	1.5
1	2	3	4
2	• Илтгэл	1 илтгэл	1.0
III	Үндэсний болон салбарын хэмжээний хурал ⁵		
1	• Уригдсан илтгэл /keynote, resource person/	1 илтгэл	2.0
2	• Илтгэл	1 илтгэл	1.5
IV	Их сургуулийн хэмжээний хурал		
1	• Үндсэн илтгэл /keynote/	1 илтгэл	0.8
2	• Илтгэл	1 илтгэл	0.5
V	Бүрэлдэхүүн сургуулийн хэмжээний хурал		
1	• Үндсэн илтгэл /keynote/	1 илтгэл	0.5
2	• Илтгэл	1 илтгэл	0.3

3.2.3 Оюуны өмчийн эрх авах, баталгаажуулах

Хүснэгт 9

№	Оюуны өмчийн бүтээлийн эрх	Хэмжих нэгж	Багц цаг
1	2	3	4
I	Шинэ бүтээлийн патент		
1	Гадаадад эрхийн хамгаалалт хийгдсэн	1 бүтээл	7.0
2	Дотоодод эрхийн хамгаалалт хийгдсэн	1 бүтээл	4.0
II	Ашигтай загварын патент		
1	Гадаадад эрхийн хамгаалалт хийгдсэн	1 бүтээл	5.0
2	Дотоодод эрхийн хамгаалалт хийгдсэн	1 бүтээл	2.0
III	Зохиогчийн эрхийн гэрчилгээ ⁶		
1	Ганцаарчилсан бүтээл	1 бүтээл	1.0

Тайлбар:

Хамтын бүтээлийн хувьд ганцаарчилсан бүтээлд ноогдох багц цагийг зохиогчдын тоонд хувааж тооцно.

3.2.4 Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн ажил гүйцэтгэх

Хүснэгт 10

№	Оюуны өмчийн бүтээлийн эрх	Хэмжих нэгж	Багц цаг
1	2	3	4
1	БХЯ-ны санхүүжилттэй төсөл, сэдэвт ажил, инновацийн төсөл /давхардуулж тооцохгүй/ • Удирдсан • Гүйцэтгэсэн • Зөвлөхөөр ажилласан	1 ажил 1 ажил 1 ажил	2.0 3.0 0.5
2	ҮБХИС-ийн санхүүжилттэй төсөл, сэдэвт ажил, инновацийн төсөл /давхардуулж тооцохгүй/ • Удирдсан • Гүйцэтгэсэн • Зөвлөхөөр ажилласан	1 ажил 1 ажил 1 ажил	1.0 2.0 0.5
3	Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, Монгол Улс дахь олон улсын байгууллагын гэрээт, захиалгат эрдэм шинжилгээ, судалгааны ажил /давхардуулж тооцохгүй/ • Удирдсан • Гүйцэтгэсэн • Зөвлөхөөр ажилласан	1 ажил 1 ажил 1 ажил	1.0 2.0 0.5
4	Гадаадын байгууллагатай хамтарсан болон олон улсын төсөл /давхардуулж тооцохгүй/ • Удирдсан • Гүйцэтгэсэн • Зөвлөхөөр ажилласан Гадаадтай хамтарсан хөтөлбөр • Удирдсан • Гүйцэтгэсэн • Зөвлөхөөр ажилласан	1 ажил 1 ажил 1 ажил 1 ажил 1 ажил 1 ажил	2.0 4.0 1.0 1.5 3.0 1.0
1	2	3	4
5	Технологи дамжуулах, инноваци нэвтрүүлэх ажил: • Байгуулсан лицензийн гэрээ /мөнгөөр тооцох боломжийг харах/	1 ажил	3.0
6	Шинэ зэвсэг, техник, тоног төхөөрөмж, инноваци, шинэ технологи бий болгож үйлдвэрлэл, сургалтад нэвтрүүлсэн бол	1 ажил	3.0-5.0 /үр дүнгээр/

3.2.5 Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацын бусад ажил гүйцэтгэх

Хүснэгт 11

№	Эрдэм шинжилгээ, судалгааны бусад ажил	Хэмжих нэгж	Багц цаг
1	2	3	4
	Эрдэм шинжилгээний сэтгүүлийн зөвлөлд ажиллах		
1.	Эрдэм шинжилгээний "Цац" сэтгүүлийн редакцын зөвлөлийн бүрэлдэхүүн (дарга, нарийн бичгийн дарга,	жилд нэг удаа	2.0

	гишүүд) /багш албан тушаалаас бусад мэргэжилтэнд хамаарна/		
	Бүрэлдэхүүн сургуулийн сэтгүүл ("Эрдэм шинжилгээний бичиг") дарга, нарийн бичгийн дарга, гишүүд) /багш албан тушаалаас бусад мэргэжилтэнд хамаарна/.	Нэг	0.4
	Их сургуулийн Хэвлэл редакцын зөвлөлд ажиллах (дарга, нарийн бичгийн дарга, гишүүд)	Нэг	0.4
2.	Бүтээл редакторлах /Зохиогчид ноогдох багцын 10-20%/ - Сурах бичиг - Монограф - Орчуулгын бүтээл	1 х.х 1 х.х 1 х.х	0.2 0.3 0.4
	Боловсруулж батлуулсан Олон улсын стандарт /ISO/ - Боловсруулсан - Оролцсон	1 стандарт 1 стандарт	2.0 0.3
4.	Боловсруулж батлуулсан Монгол Улсын стандарт /MNS/ - Боловсруулсан - Оролцсон	1 стандарт 1 стандарт	1.0 0.2
5.	Боловсруулж батлуулсан байгууллагын стандарт - Боловсруулсан - Оролцсон	1 стандарт 1 стандарт	0.5 0.1
6.	Мэргэжлийн сэтгүүлд хэвлэгдэх өгүүлэлд шүүмж бичих	1 өгүүлэл	0.3
7.	Сонсогч оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажил удирдсан /давхардуулж тооцохгүй/ - Олон улсын хэмжээнд 1-3 байр - Улсын хэмжээнд 1-3 байр - Их сургуулийн хэмжээнд 1-3 байр - Харьяа сургуулийн хэмжээнд 1-3 байр - Удирдаж оролцуулсан	1 ажил 1 ажил 1 ажил 1 ажил 1 ажил	3.0 2.0 1.0 0.5 0.2
8.	Сонсогч оюутны, олимпиад, мэргэжлийн уралдаан тэмцээн зохион байгуулах - Олон улсын хэмжээнд - Улсын хэмжээнд - Сургуулийн хэмжээнд - Харьяа сургууль	1 ажил 1 ажил 1 ажил 1 ажил	3.0 2.0 0.5 0.3
9.	Сонсогч оюутны эрдэм шинжилгээний хурал, олимпиад, мэргэжлийн уралдаан тэмцээний шүүгчээр ажиллах: - Олон улсын хэмжээнд - Улсын хэмжээнд - Сургуулийн хэмжээнд - Харьяа сургууль	1 цаг /60 мин/	0.05 0.03 0.02 0.01
1	2	3	4
10.	Сургуулийн хөгжлийн зорилго, зорилт, бодлого, стратегийг хэрэгжүүлэхтэй холбоотой бүтээлч ажил гүйцэтгэх	1 ажил	3 хүртэл /бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлийн шийдвэрээр

Тайлбар: Сэтгүүлийн редакцийн тодорхойлолтыг үндэслэнэ.

3.2.6 Бүрэлдэхүүн сургууль /тэнхим/, профессорын багийн болон бусад семинар, лекц, зохион байгуулах, оролцохтой холбоотой ажил гүйцэтгэх

Хүснэгт 12

№	Арга хэмжээ	Хэмжих нэгж	Багц цаг
1	2	3	4

1.	Профессор семинар: • Удирдах болон зохион байгуулах • Оролцох	1 семинар 1 семинар	0.1 0.05
2.	Эрдэм шинжилгээ, сургалт, арга зүйн семинар, лекц • Зохион байгуулах • Оролцох	1 семинар 1 семинар	0.1 0.05
3.	Эрдэм шинжилгээний хурал /ҮБХИС-д/ • Зохион байгуулах • Оролцох	1 хурал	0.3 0.05

Тайлбар: Эрдэм шинжилгээний хуралд салбарын 0.1, үндэсний 0.3, олон улсын 0.8 багц цагаар нэмэгдүүлж тооцно.

3.2.7 Сургуулийн гадаад болон дотоод хамтын ажиллагаа хөгжүүлэхтэй холбоотой ажил гүйцэтгэх

Хүснэгт 13

№	Арга хэмжээ	Хэмжих нэгж	Багц цаг
1	2	3	4
1.	ҮБХИС-ийн хэмжээнд гадаад дотоод арга хэмжээ зохион байгуулах /хамтарсан сургалт, семинар, мэргэжлийн уралдаан, тэмцээн/	1 арга хэмжээ	0.5
2.	Сургуулийн сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн материаллаг баазыг бэхжүүлэх, орлого, хандив оруулах: • Хөрөнгө оруулалтаар материаллаг баазыг бэхжүүлэх • Орлого, хандив оруулах	Төг	B_m

Тайлбар:

$$B_r = (M1 + M2) + 0.15 / 1.5$$

B_r - Сургуульд оруулсан орлогоос тооцох гүйцэтгэл, багц цагаар

$M1$ – Мөнгөн орлогын дүн /цэвэр орлогын дүнгээр/

$M2$ - материаллаг орлогын дүн /судалгааны багаж тоног төхөөрөмж, анги танхимын тохижилт гэх мэт хөрөнгө оруулалт, үнийн дүнгийн 10%/

R - тухайн профессор, багшийн нэг багц цагийн үнэлгээ

3. Профессор, багш нарын В цагийн ажлын гүйцэтгэлийг дараах агуулгаар тооцно.

Хүснэгт 14

№	Ажил	Үр дүн
I. Хичээлийн бэлтгэлтэй холбоотой ажлууд		
1	1 багц цагийн хичээлийн хөтөлбөр шинээр боловсруулсан бол	0.05
	2 багц цагийн хичээлийн хөтөлбөр шинээр боловсруулсан бол	0.10
	3 багц цагийн хичээлийн хөтөлбөр шинээр боловсруулсан бол	0.15
II. Сургуулийн удирдлага, зохион байгуулалттай холбоотой ажлууд		
1	ҮБХИС-ийн Эрдмийн болон Бүрэлдэхүүн сургуулийн сургалт, арга зүйн зөвлөлийн гишүүн /давхардуулж тооцож болно/	3.0
2	Бүрэлдэхүүн сургуулийн захиргааны шийдвэрээр хийсэн ажил: • Сургалт, заах арга, сургалтын технологийг боловсронгуй болгох ажил • Заавар, дүрэм, бусад баримт бичиг боловсруулах • Бусад үүрэгт ажил	0.5
III. Хамт олны төлөвшилтэй холбоотой ажлууд		
1	Хамт олны дунд нийгмийн арга хэмжээ зохион байгуулах, оролцох: • Урлагийн үзлэг наадам • Спортын тэмцээн, уралдаан • Хамт олны тэмдэглэлт арга хэмжээ	0.3
IV. Сонсогч оюутан, суралцагчдын хөгжил, төлөвшилтэй холбоотой ажлууд		
1	Багш, сонсогч, оюутны дугуйлан, клуб удирдах, зохион байгуулах	0.3
2	Зөвлөх багшаар ажиллах /10 оюутан тутамд 0.3 хичээлийн жилд/	
3	Суралцагчдын хүмүүжил, төлөвшлийн ажил; Соёл, олон нийтийн ажил зохион байгуулах	

4	Бүрэлдэхүүн сургуулийн ёс зүйн салбар зөвлөлд ажилласан бол	
5	Сонсогч, оюутнуудад давтлага өгөх /1 удаа/	0.1
6	Тамирчин сонсогч, оюутныг спортын төрлөөр цол, зэрэг ахиулбал	0.5
V. Сургуулийн нийгэмд үзүүлэх үйлчилгээтэй холбоотой ажлууд		
1	Нийтэд мэдлэг түгээх, нийгмийг соён гэгээрүүлэх зорилго бүхий эрдэм шинжилгээний хялбаршуулсан ба сурталчилгааны өгүүлэл хэвлүүлэх	0.3
2	Нийтэд мэдлэг түгээх, нийгмийг соён гэгээрүүлэх чиглэлээр лекц унших	0.3
3	- Нийгэм, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа телевиз, радиогийн нэвтрүүлэгт оролцож, мэргэжлээ сурталчлах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх - Өдөр тутмын сонин хэвлэлд өгүүлэл, нийтлэл бичих - Үндэсний зөвлөхөөр ажиллах - Шинжээчээр ажиллах - Ажлын хэсгийн гишүүнээр ажиллах /ажлын хөлс авах нөхцөлд/	0.3 0.5 0.5 0.5 0.3
4	Хөтөлбөрийн магадланд оролцож тооцуулсан бол • Удирдсан • Оролцсон	0.5 0.3
5	Баяр наадмын хамгаалалт, нийтийн хэв журам сахиулах, түймэр унтраах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах бусад дайчилгаа, үйл ажиллагаанд оролцсон, сонсогч удирдан ажилласан.	0.3
6	Багшийн хөгжлийг дэмжих багт ажилласан бол (ажилласан үр дүнгээр)	0.5

4. Профессор, багш нарын Г цагийн ажлын гүйцэтгэлийг дараах агуулгаар тооцно.

Хүснэгт 15

№	Багшийн хөгжлийн чиглэл	Үр дүн
1	2	3
1	Шинэ багшийг дагалдуулж, зөвлөгөө өгсөн байдал (багшийн тоогоор)	0.3
2	Шинэ багшийн чиглүүлэх сургалтад хамрагдаж сертификат авсан	0.3
3	Нээлттэй хичээл зохион байгуулах	0.3
4	Нээлттэй хичээлд оролцох	0.1
5	Клуб, дугуйланд оролцох	0.1
6	Багш нарын сургалтад хичээл заасан	0.2
7	Хичээл заах шинэ арга зүй хэрэгжүүлсэн байдал	0.3
8	Мэргэжлийн чиглэлээр боловсролоо дээшлүүлсэн (зэрэг ахиулсан бол)	1.0
9	Багш, боловсролын чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн сертификат авсан	0.5
10	Мэргэшсэн чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн сертификат авсан	0.5
11	Профессор, багшийн хичээлд сууж, туршлага судалж зөвлөгөө авсан	0.1
12	Сургалт семинарт оролцож сертификат авсан • гадаад • дотоод	*0.02 *0.01
13	Гадаад хэлний түвшингээ ахиулсан /албан ёсны нотломжтой/	1.0
14	Гадаад хэлний сургалтад сууж зохих түвшнийг баталсан сертификат авсан	0.5
15	Гадаад хэлний түр сургалт, хичээлд хамрагдсан, хэл сурах чиглэлээр бие дааж ажилласан	0.2

Тайлбар:

- Б цаг тооцох журмын 3.2.6.2 дахь заалтыг Г цаг тооцох 3.4.12 дэх заалтуудыг давхцуулж тооцуулахгүй.
- Сургалтад хамрагдсан бол 90 минутын сургалтыг 2 цагаар тооцно.
- Нээлттэй хичээлийг хичээлийн жилд 2-оос илүүгүй зохион байгуулсан байх бөгөөд ЗАЗ-н төлөвлөгөөнд тусгагдаж харьяа сургуулийн тэнхим, төвийн дарга (СХ-ийн дарга эсвэл бүрэлдэхүүн сургуулийн захирал)-аар батлуулна.

ДӨРӨВ. ПРОФЕССОР, БАГШ НАРЫН 1 БАГЦ ЦАГИЙН ҮНЭЛГЭЭ

4.1 Профессор, багш нарын нэг багц цагийн үнэлгээг тухайн багшийн эрдмийн зэрэг цолоос хамааруулан дараах хувь хэмжээг баримтлан тооцож олгоно.

Хүснэгт 16

№	Багшийн албан тушаалын шатлал	1 багц цагийн хөлс	1 цагийн хөлс ⁷
1	Шатлалын профессор	468,480.00	9,760.00
2	Шатлалын дэд профессор	445,920.00	9,290.00
3	Ахлах багш	424,800.00	8,850.00
4	Багш, тестийн мэргэжилтэн	424,800.00	8,850.00
5	Багш	386,400.00	8,050.00

Багш 1,159,200 – 720,000 – 439,200

Профессор 1,405,440 – 720,000 – 685,440

Тайлбар:

1. Профессор, багш нарын бодит цагаар тооцож ажлын хөлс олгоход 1 цагт харгалзах үнэлгээг баримтална.
2. Профессор, багшид олгох илүү цагийн хөлсийг дээрх үнэлгээгээр тооцож олгоно.
3. Багш нарын багц цагийн үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор баталсан ТҮ цалингийн зэрэглэлийн дагуу нэмэгдүүлсэн.
4. Нэгж цагийн хөлс $= (ТҮ - 11) / (176 \text{ цаг}) = 1,718,000 / (176 \text{ цаг}) = 9760$ төгрөг
Багц цагийн хөлс /шинэ/ = (Нэгж цагийн хөлс) * (1 багцын хичээлийн цаг);
Багц цагийн хөлс /шинэ/ = $(9760) * (48) = 468,480.00$ төг гэх мэтчилэн тооцоолсон болно;
4.2 Гэрээт профессор, багш нарын нэг багц цагийн үнэлгээг тэдгээрийн эрдмийн зэрэг цолны дагуу 4.5-д заасан хувь хэмжээгээр олгоно.
4.3 Гадны байгууллагад ажилладаг эрдэмтэн, судлаачдыг урьж эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавиулахад олгох хөлсийг дараах үнэлгээг баримтална.

Хүснэгт 17

№	Эрдмийн зэрэг, цол	Нэг багц цагийн үнэлгээ /төг/ ^x
1	Шинжлэх ухааны доктор /Sc.D/, профессор	/1 багц цаг*0.8/
2	Доктор /Ph.D/, профессор	/1 багц цаг*0.7/
3	Доктор /Ph.D/, дэд профессор	/1 багц цаг*0.6/
4	Доктор /Ph.D/	/1 багц цаг*0.5/
5	Магистр	/1 багц цаг*0.4/
6	Зочноор урьж лекц уншуулахад эрдмийн зэрэг, цол харгалзахгүй	445,920.00

4.4 Төгсөлтийн шалгалтын комисс, бакалаврын хамгаалалтанд орж ажилласан профессор, багш, гадны байгууллагын төлөөллийг ажилласан цагаар нь бодож цагийн хөлс олгоно. Цагийн хөлсийн үнэлгээг боловсролын зэрэгт үндэслэн доорх жишгээр тооцно.

Хүснэгт 18

№	Боловсролын зэрэг	1 цагийн хөлс ^x
1	Шинжлэх ухааны доктор	9,760.00
2	Боловсролын доктор	9,290.00
3	Магистр	8,850.00
4	Бакалавр	8,050.00

4.5 Орон нутаг зохион байгуулагдсан эчнээ сургалтад хичээл заасан болон элсэлтийн шалгалтад ажилласан багшид албан томилолтын зардлыг тухайн жилийн төсөвт нийцүүлэн олгоно.

ТАВ. МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН БАГШИЙН БАГЦ ЦАГИЙН ТООЦОО

5.1 Багшийн сургалтын цагийн ачаалал, багц цаг нь албан тушаалын тодорхойлолт, албан тушаалын зэрэглэл, мэдлэг ур чадварын түвшин, ажлын үнэлгээтэй харилцан

уялдаатай байна. Мэргэжлийн болон ерөнхий эрдмийн багшийн ажлын ачааллыг багц цагаар тооцох бөгөөд жилд нэг багш 20 багц цагийн ажлыг гүйцэтгэнэ.

5.2 Багшийн багц цаг нь танхимын ба танхимын бус сургалтын үйл ажиллагааны багц цагаас бүрдэнэ.

5.3 Танхимын сургалтын багц цагт онол /лекц, семинар/, сургалтын хөтөлбөрт тусгагдсан танилцах, мэргэжлийн болон үйлдвэрлэлийн дадлага, сургалт болон төгсөлтийн үйл ажиллагааг хамруулна.

5.4 Танхимын бус сургалтын багц цагт сургалтын үйл ажиллагааг дэмжих, багшлахуйн болон мэргэжлийн хөгжил, сургалт (Б), иргэд, түншлэгч байгууллагуудтай хамтран ажиллах, сургуулийн дотоод үйл ажиллагаа (В), суралцагчийн хөгжлийг дэмжих (Г) үйл ажиллагааг хамруулж тооцно.

5.5 Үндсэн орон тоонд ажиллаж байгаа мэргэжлийн багш нь ур чадвар, тухайн мэргэжлийн чиглэлээр ажилласан жилд үндэслэн тэнхимийн дарга (мастер багш), ахлах багш, багш, ерөнхий эрдмийн багш нь ахлах багш, багш, гэсэн 3 түвшинтэй байна.

5.6 Багшийн сургалтын нэг багц цагт онолын болон сургууль дээрх дадлага сургалтын хувьд 36 цаг, үйлдвэрлэлийн дадлага болон төгсөлтийн дадлага үйл ажиллагааны хувьд 72 цагийг тооцно.

5.7 Багшийн танхимын бус сургалтын нэг багц цагт 72 цагийн сургалтаас гадуурх ажлын гүйцэтгэлийг тооцно.

Танхимын болон танхимын бус сургалтын багц цагийг ноогдол

Багшийн ур чадварын түвшин	Танхимын сургалтын багц цаг (А)	Танхимын бус сургалтын багц цаг (Б, В, Г)
	Жилийн ачаалал багц цаг	Жилийн ачаалал багц цаг
Тэнхимийн дарга (Мастер багш)	16	4
Ахлах багш	17	3
Багш	18	2

5.8 Мэргэжлийн болон техникийн боловсролын хичээлийн нэг цагийн хэмжээ нь 45 минут байх бөгөөд хоёр цагийн дунд нь завсарлагагүйгээр 90 минутад багтаан явуулахаар хичээлийн хуваарьт тусгана.

5.9 Багшийн дутагдал эсвэл багш хүндэтгэн үзэх шалтгаанаар сургалт зохион байгуулах боломжгүй тохиолдолд сургалт, судалгааны албаны дарга, сургалт, төлөвлөлт хариуцсан албан тушаалтнууд хичээл зааж болох бөгөөд сургалтын багц цаг нь жилд 8 багц цагаас хэтрэхгүй байна.

5.10 Багш нь бусад албан тушаалын чиг үүргийг хавсран гүйцэтгэсэн тохиолдолд жилд гүйцэтгэх багц цагийн ачааллыг 40 хүртэлх хувиар хорогдуулж болно.

5.11 Танхимын бус сургалтын багц цагийн гүйцэтгэлийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/103 дугаар тушаалаар баталсан "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшийн ажлын цагийн ачаалал, багц цагийн журам"-ын 3.7 дахь заалтыг үндэслэн тооцно.

5.12 Энэ журмын 5.3 болон 5.4 дахь багц цагийг хооронд нь шилжүүлж тооцохгүй.

5.13 Багшийн багц цагийн гүйцэтгэлийг хагас жил, жилээр тооцно. Баталгаажуулсан багц цагийн тооцоог бүрэлдэхүүн сургуулийн сургалт судалгааны алба, сургалтын хэлтэс хянан, сургалт эрхэлсэн дэд захирлаар уламжлуулан их сургуулийн захирал баталгаажуулна.

5.14 Гадны багш, инженер, техникийн мэргэжилтнийг цагаар ажиллуулсан тохиолдолд цагийн багшийн гэрээ байгуулж, энэ журмын 4.5 дахь хэсэгт заасны дагуу тооцож олгоно.

5.15 Танхимын ба танхимын бус сургалтын ажлын ногдол багц цагийг хүндэтгэх бус шалтгааны улмаас биелүүлээгүй нөхцөлд гүйцэтгэсэн багц цагийн хөлсийг тухайн багц цагт харгалзах хэмжээгээр багшийн цалин хөлснөөс хасаж тооцно.

ЗУРГАА. БАГШИЙН ЦАГИЙН НООГДЛЫГ ТӨЛӨВЛӨХ, ГҮЙЦЭТГЭЛИЙГ ДҮГНЭХ, ХЯНАХ

6.1. Дараагийн хичээлийн жилд гүйцэтгэх нийт сургалтын ажлын цагийг сургалт хариуцсан нэгжээс ирүүлсэн хичээл тандалтын дүгнэлтийг үндэслэн тухайн оны 05-р сард

тэнхимийн дарга тооцож гаргана. Багш нарын сургалтын цагийг жигд хуваарилсан байх шаардлагатай бөгөөд багш хүрэлцэхгүй, байхгүй нөхцөлд тухайн багшаар үндсэн нормын нь 40% хүртэл илүү цаг заалгах, эсвэл цагийн багш ажиллуулна. Мөн хичээлийн явцад өвчилсөн, ажлаас өөрчлөгдсөн, гадаад дотоодод томилолтоор ажилласан багшийн хичээлийг тэнхимийн даргын зөвшөөрлөөр өөр багшид шилжүүлэн илүү цаг гүйцэтгүүлж болно. Онцгой тохиолдолд үндсэн нормын 40%-иас хэтэрсэн илүү цаг заалгах шаардлага гарвал бүрэлдэхүүн/ харьяаллын сургуулийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

6.2. Хичээлийг мэргэжлийн тэнхим хариуцах бөгөөд тэнхимийн дарга нь багш нарынхаа өөрийн сургууль болон бусад бүрэлдэхүүний сургуульд заах хичээлийн ноогдлыг зохицуулна. Сургалт хариуцсан нэгжийн удирдлага бусад сургуулийн багштай шууд тохирон хичээл заалгах, цагийн багшийн журмаар ажиллуулахыг хориглоно. Сургууль хоорондын тооцоог суралцагчийн багц цагт үндэслэн хийх бөгөөд тухайн хичээлийн жилийн нийт багц цагийн тооцоог сургалт хариуцсан нэгж нэгтгэн хянаж 2.9-д заасны дагуу нягтлан шалгаснаар Сургалт хариуцсан дэд захирлын зөвшөөрлийг үндэслэн ҮБХИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.

6.3. Багшийн ажлын эцсийн гүйцэтгэлийн үр дүнг хянан дүгнэж илүү цагийн хөлсийг олгоно. Цэргийн багшид илүү цагийн хөлс олгохтой холбоотой асуудлыг холбогдох хууль, тогтоомж бусад журамд нийцүүлнэ.

СУРГАЛТЫН ХЭЛТЭС